




Co-funded by the
Erasmus+ Programme
of the European Union



Urban Resilience and Adaptation for India and Mongolia:
curricula, capacity, ICT and stakeholder collaboration to support green & blue infrastructure and nature-based solutions
619050-EPP-1-2020-1-DE-EPPKA2-CBHE-JP



Тогтвортой хөгжил

Цахим хичээлийн танилцуулга ENVI312/ENVI618

Дэд проф С.Энхцэцэг, Дэд проф Д.Даваадорж

Монгол Улсын Их Сургууль

<https://online.num.edu.mn/courses/>

АГУУЛГА

1

- Хичээлийн тухай ба залгамж холбоо

2

- Хичээлийн зорилго, ач холбогдол, агуулга

3

- Эзэмших мэдлэг, ур чадвар

4

- Даалгавар ба үнэлгээ

5

- Сурах бичиг ба сургалтын материал

6

- Лекцийн төлөвлөгөө

7


- Семинар хичээлийн төлөвлөгөө

8

- Заах арга барил ба цахим хичээлд хэрхэн хамрагдах вэ?



Co-funded by the
Erasmus+ Programme
of the European Union



Urban Resilience and Adaptation for India and Mongolia:
curricula, capacity, ICT and stakeholder collaboration to support green & blue infrastructure and nature-based solutions
619050-EPP-1-2020-1-DE-EPPKA2-CBHE-JP



Хичээлийн зорилго, залгамж холбоо

ХИЧЭЭЛИЙН ЗОРИЛГО, АЧ ХОЛБОГДОЛ

- Энэхүү хичээлийн үндсэн зорилго тогтвортой хөгжлийн үзэл санаа, ойлголт, үзэл баримтлал, үйл явцыг байгаль, нийгмийн шинжлэх ухааны ойлголт, тайлбараар өргөн хүрээнд авч үзсэн. Уур амьсгалын өөрчлөлтийг дэлхийн хөгжлийн үе шат, тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх бодлого, стратегийг үндэсний, олон улс, глобал түвшинд авч үзнэ.

- Улс бүр тогтвортой хөгжил, хүртээмжтэй өсөлтийг хангах бодлого, стратегийг хэрэгжүүлэх глобал үйл явцыг ажиглах, үнэлэлт дүгнэлт өгөх, байгаль орчны чиглэлээрх дэлхийн олон талт хамтын ажиллагааны механизмыг МУ-ын ногоон хөгжлийн стратеги, тогтвортой хөгжлийг хангахад оновчтой ашиглах мэдлэг чадвар, харилцааны өндөр мэдрэмжтэй үндэсний мэргэжилтэн бэлтгэхэд оршино.

Хичээлийн уялдаа, залгамж шинж:

- Тогтвортой хөгжлийн ойлголтуудыг уур амьсгалын өөрчлөлттэй холбон байгалийн шинжлэх ухааны /физик газар зүй, тектоник зүй тогтол, ноосфер- антропоцен, биологийн олон янз байдал зэрэг/ хүчин зүйлтэй холбосон шинжлэх ухааны гол ойлголттой танилцуулна.
- Тогтвортой хөгжлийг хэмжих нийгэм, эдийн засгийн ойлголт, хэмжүүр, үзүүлэлттэй танилцаж, харьцуулах, анализ хийнэ.
- Судалгааны салбар дундын хүрээнд тогтвортой хөгжлийн ойлголт, үзэл баримтлал, хөрш орнууд (ОХУ, БНХАУ-ын бодлого) болон НҮБ-ийн төрөлжсөн болон тусгайлсан мэргэжлийн байгууллагуудын судалгаа, алсын хараа, хөтөлбөрүүдтэй танилцана.

ХИЧЭЭЛИЙН ЗАЛГАМЖ ХОЛБОО

Өмнө үзсэн байх хичээлийн нэр, индекс:

1. Хүрээлэн буй орчин судлал ENVI200

Зэрэгцүүлэн үзэхэд тохиромжтой хичээлийн нэр, индекс:

1. МУЭЗГБ: уламжлал шинэчлэл INEC703

ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд тулгуурласан дэлхий нийтийн хамтын ажиллагааны хөгжлийн түүхийг ХХ, ХХI зууны эхэн үеийн түүхэн үйл явдлуудтай холбон авч үзэхдээ салбар дундын судалгааны аргачлалд тулгуурлан авч үзнэ. Улс орны хөгжлийн стратегиуд өөр боловч нийтлэг зорилго, үнэт зүйл, үзэл баримтлал, хөгжлийн загварууд даяаршил, хамтын ажиллагааны нөлөөгөөр улам бүр ижилсэж байгааг уур амьсгалын өөрчлөлт, дулаарал, агаарын бохирдол, олон улсын далайн болон сансрын нөөцийг хүн төрөлхтний амьдрах орчин сайжруулах, байгаль орчны хамгаалах чиглэлд хамтарч ашиглах нийтлэг хүсэл эрмэлзлэлтэй холбон авч үзнэ.

Монгол улсын ХБО-ны асуудлыг тогтвортой хөгжлийн 17 зорилтын хүрээнд тодорхойлж хэрэгжүүлэх бодлогын хэрэгжилт, олон улсын хамтын ажиллагааны төсөл, хөтөлбөрүүдийн талаар харьцуулан судлахдаа суралцагчид өөрийн ахуй амьдралд гарч буй орчны өөрчлөлтийг хичээлийн семинар, багийн судалгааны ажилдаа тусгаж, бодит учир шалтгааныг улс орон, хөршүүд болон бүс нутаг, олон улсын болон глобал түвшинд шатлан авч үзэж онол, практикийн мэдлэг эзэмших ач холбогдолтой.

ХИЧЭЭЛИЙН ДААЛГАВАР

Лекцийн хичээл бүрийн төгсгөлд тухайн сэдвийн ойлголтыг бататгах түлхүүр асуултууд байгаа бөгөөд суралцагсад түүнд харивулснаар өөрийн мэдлэгийг бэхжүүлнэ.

ХИЧЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ (ирц, явц, шалгалт)


Дараах хэлбэрүүдээр суралцагчдын мэдлэг, ур чадварыг үнэлнэ. Үүнд:

1. Ирц буюу хичээл хандалт
2. Явцын шалгалт
3. Ур чадварын шалгалт
4. Улирлын шалгалт

Дүгнэх зүйл	Оноо	Тайлбар
Ирц	20	Цахим хичээлд хандалтаар үнэлнэ.
Явцын шалгалт	30	Тогтвортой хөгжлийн зорилтууд, хүрэх арга зам, үйл ажиллагааны чиглэлээр эссе бичиж тооцуулах
Улирлын шалгалт	30	Лекц, семинарын хичээлийн агуулгаар холбогдох шалгалт авна
Бие даалт	20	Улс орнуудын байгаль орчны чиглэлээр шинээр хөгжүүлэн, хэрэгжүүлэх буй хүрээлэн буй орчны технологийн чиглэлийн талаар бие даалт бэлтгэн тооцуулах
Нийт	100	



Co-funded by the
Erasmus+ Programme
of the European Union



Urban Resilience and Adaptation for India and Mongolia:
curricula, capacity, ICT and stakeholder collaboration to support green & blue infrastructure and nature-based solutions
619050-EPP-1-2020-1-DE-EPPKA2-CBHE-JP



Хичээлээр эзэмших мэдлэг, ур чадвар


Мэдлэгтэй болох	<ul style="list-style-type: none"> ~ НҮБ-аас шинээр гаргасан Тогтвортой хөгжлийн 17 зорилтыг тус бүрд нь нарийвчлан мэдэх ~ Тогтвортой хөгжлийн түүхэн хөгжил, гол онол, үзэл баримтлалыг мэдэх ~ Тогтвортой хөгжилд нөлөөлж буй гол асуудлууд болон тогтвортой хөгжлийг практикт хэрхэн хэрэгжүүлэх талаар тодорхой тайлбарлах
Ойлгох	<ul style="list-style-type: none"> ~ Сэргээгдэх нөөцийн хэрэглээнд шилжихэд нийгэмд тулгарч буй сорилтуудыг судлах ~ Тогтвортой байдлын үзэл баримтлалын үндэс болох шинжлэх ухаан, технологи, эдийн засаг, улс төрийн уялдааг ойлгох ~ Нөөцийг хэтрүүлэн ашиглах, хүн амын өсөлт, эдийн засгийн өсөлт, тогтвортой байдлын үр дагаврыг ойлгох
Хэрэглэх	<ul style="list-style-type: none"> ~ Тохиромжтой нотлох баримт, нөөцийг ашиглан аргумент эсвэл шийдлийн чанар, итгэл үнэмшил, хязгаарлалтыг үнэлэхийн тулд шүүмжлэлтэй сэтгэх чадвартай байх ~ Тогтвортой хөгжлийн ололт амжилтыг үнэлэх аргуудыг тодорхойлж хэрэглэх ~ Тоон мэдээг ашиглах
Анализ хийх	<ul style="list-style-type: none"> <input type="checkbox"/> Тогтвортой байдлын талаарх мэтгэлцээнд маргаан, ижил төстэй байдал, санал зөрөлдөөнд дүн шинжилгээ хийх, харьцуулах
Нэгтгэн дүгнэх	<ul style="list-style-type: none"> <input type="checkbox"/> Зохих риторик стандартыг (жишээлбэл, үзэгчдийн дасан зохицох, хэл яриа, маргаан, зохион байгуулалт, нотлох баримт гэх мэт) ашиглан аман болон бичгийн хэлбэрээр үр дүнтэй харилцах. <input type="checkbox"/> Оюутнуудад тогтвортой хөгжлийн талбар дахь шалтгаан, шийдлийн талаархи хувь хүн, нийгэм, тэдний үүрэг оролцоог ойлгох чадварыг хөгжүүлэх чадварыг хөгжүүлэх

Хүрээлэн буй орчны асуудал, тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын талаар дэлхий нийтээрээ хэрэгжүүлж буй бодлого, Монгол улсын үндэсний стратеги хөтөлбөр ногоон хөгжлийн үзэл баримтлалын талаар тодорхой ойлгох, Монгол улсын байгалийн нөөц, түүнийг ашиглах талаар хэрэгжүүлж буй бодлого, эрх зүйн орчин, хөрөнгө оруулалтын байдал, технологийн шинэчлэлийн хөтөлбөрийг тодорхойлох зэрэг асуудлаар системтэй мэдлэгтэй болно.

Бизнес, эдийн засаг, хууль эрхзүй, байгаль орчны зэрэг олон салбаруудын мэдээлэл ашиглан салбар дундын асуудлыг нэгтгэн дүгнэж уялдаа холбоо, дэс дарааллыг тодорхойлж учир шалтгааныг судалгааны (тоон болон чанарын) арга зүй ашиглан тайлбарлах чадвартай болно.



Co-funded by the
Erasmus+ Programme
of the European Union



Urban Resilience and Adaptation for India and Mongolia:
curricula, capacity, ICT and stakeholder collaboration to support green & blue infrastructure and nature-based solutions
619050-EPP-1-2020-1-DE-EPPKA2-CBHE-JP



Сурах бичиг, сургалтын материал

Үндсэн сурах бичиг:


1. Sarkar, Runa, and Anup Sinha. Economics of Sustainable Development, Business Expert Press, 2016. ProQuest Ebook Central, <https://ebookcentral.proquest.com/lib/hselibrary-ebooks/detail.action?docID=5184983>. Англи хэлээр.
2. The Handbook of Global Climate and Environmental Policy edited by Robert Falkner., 2013. Wiley-Blackwell 538 p
3. Political Ecology: A Critical Engagement with Global Environmental Issues., Tor A. Benjaminsen Hanne Svarstad. 2020

Нэмэлтээр унших ном, материал:

1. Монгол Улсын Их Хурал. 2016 оны 19-р тогтоол. Монгол Улсын Тогтвортой Хөгжлийн Үзэл Баримтлал -2030.
2. Монгол улсын ҮАБ-ын үзэл баримтлал, 2010 он
3. Монгол улсын Гадаад бодлогын үзэл баримтлал, 2011 он
4. МУ-ын Ногоон эдийн засгийн үндэсний стратеги, 2010
5. Бодлогын баримт бичиг: Алсын хараа – 2050, 2020 он



Co-funded by the
Erasmus+ Programme
of the European Union



Urban Resilience and Adaptation for India and Mongolia:
curricula, capacity, ICT and stakeholder collaboration to support green & blue infrastructure and nature-based solutions
619050-EPP-1-2020-1-DE-EPPKA2-CBHE-JP




Лекцийн төлөвлөгөө

7 хоног	Хичээлийн сэдэв	Сэдвийн агуулга	Цаг
1	Тогтвортой хөгжлийн үзэл санаа, үзэл баримтлалын үүсэл хөгжил, цгс хан олага	Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын суурь ойлголт, байгаль орчны өөрчлөлтөнд дасан зохицох нийгэм-эдийн засгийн хөгжлийн загвар, тулгамдаж буй асуудал	2
2	Хүртээмжтэй есөлт, хөдөлмөрийн хөлс, хэрэглээ ба амьдралын хэв маяг	Хүртээмжтэй есөлт, түүнийг тодорхойлох ойлголт, хэмжүүр, шалгуурыг хөдөлмөрийн хөлс, үнэлэмж, хэрэглээний бүтэц, амьдралын хэв маягт гарч буй өөрчлөлттэй холбон үзэх	2
3	Тогтвортой хөгжлийн үнэлэмж	Тогтвортой хөгжлийн үнэлгээний арга зүй, хэрэглүүр, инноваци, системийн тулгуур ойлголтууд- эдийн засаг улс төр, нийгмийн хөгжил	2
4	Дэлхийн Хүрээлэн буй орчны аюулгүй байдлын төлөв Биологийн олон янз байдал, biodiversity	Дэлхийн геомандлын бүрэлдэхүүн хэсгүүд, тэдгээрийн өөрчлөлт, хувирал, ноосфер – антропоцен – байгалийн нөхцөлөөс шалтгаалсан улс орны хөгжил- геo эдийн засгийн тулгуур ойлголтууд. Биологийн олон янз байдал, ойлголтууд	2
5	Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн талаарх үзэл баримтлалууд, таамаглалууд, баримтууд	Дэлхий уур амьсгалын төлөв байдал, түүний өөрчлөлт хувирал, судалгааны арга, түүхэн болон орчин үеийн уур амьсгалын өөрчлөлтийн тухай. Түүнд дасан зохицох, бууруулах арга технологи, эдийн засаг, нийгмийн нөлөөлөл	2
6	Хоол хүнсний хангамж, хүрээлэн буй орчны чанараас үүдэлтэй хүн амын эрүүл ахуйн асуудал	Байгалийн бүс бүслүүрийн суурь ойлголт, байгалийн нөхцөл, нөөцийн хуваарьжилт, хүнсний эрүүл ахуй, хангамжид байгалийн нөхцөл, нөөц нөлөөлөх тухай. Байгалийн бүсийн ялгарал, нийгэм-эдийн засагт үзүүлэх нөлөөлөл	2
7	Тогтвортой хөгжлийг хангах эдийн засгийн арга хэрэгслүүд, тэдгээрийг хэрэгжүүлэхэд тулгарах сорилтууд	Хүрээлэн буй орчин, тогтвортой хөгжлийг нийгэм, эдийн засаг, бизнес, байгаль орчин, нөөцийн менежмент, удирдлагын зэрэг олон талаас нь авч үзсэн аргчлалуудтай танилцана.	2
8	Public-Private Partnership механизмын хэрэгжилт	Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны олон талт хувилбаруудыг гадаад улс орнууд, дотоодын ААН-ийн туршлагатай уялдуулан хэйс боловсруулах, түүх, жишээ, баримтыг харьцуулан судлаж аргачлал боловсруулах	2
Явцын шалгалт		Тогтвортой хөгжлийн зорилтууд, хүрэх арга зам, үйл ажиллагааны чиглэлээр эссе бичиж тооцуулах	

9	Улс орнууд, бүс нутаг, олон улсын ЖБО-ны байгууллагуудын бүтэц, тогтолцоо, хамтын ажылагааны механизм	Олон улсын байгууллага, хүрээлэн буй орчны чиглэлийн олон улсын байгууллагуудын тухай. National Geography Society-Үндэсний Газарзүйн нийгэмлэг, НҮБ-ийн Бүс нутаг... г.м.	2
10	Тогтвортой хөгжлийн Хөрөнгө оруулалтын санхүүжлтийн олон талт механизм	Хүрээлэн буй орчин (ЖБО), НҮБ-ийн ТХ-ийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон хамтын ажылагааны олон талт, хоёр талт механизмьг глобал, бүс нутаг, улс хоорондын болон дотоодын түвшинд авч үзэх, тухайн салбарын онцлог, ялгаатай байдлыг х аргачлах	
11	МУ-ын ЖБО-ны бодлого, эрх зүйн орчны өөрчлөлт шинэчлэлт, сорилт - МУ-ын ЖБО-ны уламжлалт үзэл санаа, Ногоон хөгжлийн концепц, хэрэгжлэлт	Монгол орны байгаль орчны чиглэлийн хууль эрхзүй, бодлогын үүсэл, шинэчлэл. Уул уурхайн хөгжилтэй уялдан үүсэж буй тулгамдсан асуудал, ногоон хөгжлийн тухай ойлголтууд	
12	Олон улсын ЖБО-ны эрх зүйн зохицуулалтын өөрчлөлт	Олон улсын хүрээнд хүрээлэн буй орчны чиглэлээр хамран мөрдөгдөж буй бодлого, зохицуулалт, нийгэм-улс төрийн байдалтай уялдан үүсэж буй эрхзүйн өөрчлөлт шинэчлэлт	2
12	ОХУ-ын ЖБО-ны бодлого, зохицуулах механизмьн онцлог	Дэлхийн хуурай газрын хамгийн их хувийг эзэлдэг, ойн сан, цэвэр усны нөөцөөр тэргүүлэгч хойд кери ОХУ-ын ЖБО талаар хэрэгжүүлж ирсэн уламжлалт бодлого, орчин үеийн бодлогын үзэл баримтлал, үйл ажылагааны төрлүүд, хамтын ажылагааны хэлбэрүүдийг манай улсын эрчим хүч, тээвэр, байгалийн нөөц, усны асуудлуудын жишээн дээр нарийвчлан үзэж судлах	2
13	БНХАУ-ын ЖБО-ны бодлого, зохицуулах механизмьн онцлог	Том газар нутагтай, хэрэглэгч зах зээлтэй, технологийн баялаг туршлагатай БНХАУ-ын ЖБО талаар хэрэгжүүлж ирсэн уламжлалт бодлого, орчин үеийн бодлогын үзэл баримтлал, үйл ажылагааны төрлүүд, хамтын ажылагааны хэлбэрүүдийг манай улсын газрын тос, төмөр замын тээвэр, уул уурхайн нөөц, цөлжилтийн жишээн дээр нарийвчлан авч үзэж судлах	2
14	Дэлхийн улс орнуудын хотжилтын шалтгаан	Хот, суурин газрын үүсэл хөгжлөл, тэдгээрийн ялгаатай байдал, хотжилт үүсэх нөхцөл болон түүнийг дагалдан гарах байгаль орчин, нийгэм, эдийн засгийн асуудалууд, хотын тогтвортой хөгжлийн тухай ойлголт, оролцогч талууд	2
15	Их гүрнүүдийн зэвсэглэлээр хөөцөлдөх бодлого, хими, биологийн туршилтаудын ҮР дагавар	Цөмийн зэвсгээр хөөцөлдөх (ЦЗХ) өрсөлдөөн, технологийн дэвшилээс үүдэн улс хоорондын гэрээ эрх зүйн орчинд гарч буй өөрчлөлтийн нөлөөг судлах, энх тайвнаар зохицуулах институцийн механизмыг авч үзэх, хувилбар дэвшүүлэх	2
16	Дүгнэлт хичээл	Дээрх сэдвүүдийг нэгтгэн салбар дундын асуудлаар хэлэлцүүлэг зохион байгуулах, ярилцах	2
Улирлын шалгалт		Лекцийн хичээлийн агуулгаар улирлын эцэст шалгалт өгнө	
Нийт			32



Co-funded by the
Erasmus+ Programme
of the European Union



Urban Resilience and Adaptation for India and Mongolia:
curricula, capacity, ICT and stakeholder collaboration to support green & blue infrastructure and nature-based solutions
619050-EPP-1-2020-1-DE-EPPKA2-CBHE-JP



Семинарын хичээлийн төлөвлөгөө

Семинарын хичээл:

7 хоног	Хичээлийн сэдэв	Сэдвийн агуулга	Цаг
1	Тогтвортой хөгжлийн зорилт: 17 зорилт	Тогтвортой хөгжлийн ирээдүйн хандлага нь дэлхий нийтийг хамарсан аргагүй, хандлага хөгжүүлэх шаардлагатай. Мөн 17 зорилтын давуу бол сул талыг тодорхойлох: Парис, Рио Де Жанейро, Киото протокол, тунхаглалуудыг талаар авч үзэх	2
2	ХХI зууны хөгжлийн тулгуур үзэлд гарч буй өөрлөлтийн шалтгаан	Эдийн засгийн хөгжил-байгаль газарзүйн хүчин зүйлээс шалтгаалах, хүний эрх, тэгш боловсролын асуудал, Хөгжил нь хүнд тулгуурлах, эдийн засгийн боломж хангах, байгалийн нөхцөлд түшиглэх, хөгжлөөс үүсэх сөрөг нөлөөлөл г.м	2
3	ТХ-ийн нийгэм эдийн засгийн шалгуур үзүүлэлтүүд	Глобал, бүс нутаг, орон нутаг, улс хоорондын ялгааг харуулсан нийгэм, эдийн засаг, байгаль орчин, эрчим хүч, худалдаа зэрэг голлох салбаруудын хамаарлыг харуулсан үзүүлэлтүүдийг авч үзэх, нэгтгэх, харьцуулах	2
4	Ноосфер – антропоцен үеийн сорил	Дэлхийн геомандлын бүрэлдэхүүнд оюун ухаант мандал буюу ноосфер үүсэх, хөгжил тухай сургааль, Антропоцен эрин үе ялгах тухай	2
5	Хүрээлэн буй орчны өөрчлөлт: дэлхийн дулаарал эсвэл орчны бохирдол	Биологийн олон янз байдал, дэлхийн нөхцөл, нөөц, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, орчны бохирдолын асуудал, үр дүн, үйлдвэржилт-ХАА салбар, хотжилт	2
6	Дэлхийн ХАА-н мужлал, хөгжлийн түүх, хөрс-газрын доройтол	ХАА-н салбарын үүсэл хөгжил, тэдгээрийн хөгжлийн түүх. Газар тариалан, МАА-аас эдийн засаг, нийгэмд үзүүлэх нөлөөлөл, газрын доройтол, хөрсний эвдрэл, тулгамдсан асуудал болох	2
6	Ядуурал, хоол хүнсний хангамж, хүний эрх Олон улсын хоол, хүнсний хангамж, хүртээмж	Хүн амын тооны өсөлт хязгаарлах хүчин зүйл эсэх, эдийн засгийн боломж үүсгэх, баялгын тэгш бус хуваарилалтаас үүдэлтэй ялгаатай байдал	2
7	Төр, олон нийтийн хамтын ажиллагаа,	Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод тарих” хөтөлбөрийн жишээг авч үзэх	2

8	Монгол орны байгаль орчны тулгамдсан асуудал- нийгмийн асуудал	Монгол орны уламжлалт МАА-н онцлог, байгаль орчны хамгаалах уламжлалт мэдлэг, шинэ тутам үүсэж буй тулгамдсан асуудал, уул уурхай, хотжилт, цөлжилт, ХБО-ийн өөрчлөлтөөс үүсэх нийгмийн асуудалууд	2
9	Олон улсын хүн ам зүйн асуудлууд	Ажиллах хүчний гадаад, дотоод хөдөлгөөний динамик, тархац, амьдралын үнэлэмж, хөдөлмөрийн хөлс, зах зээлийн өрсөлдөөн, технологийн хөгжил, цахим шилжилтээс үүдэлтэй олон улсын хөдөлмөрийн зах зээлд гарч буй өөрчлөлтийг тайлбарлах, нөлөөг тодорхойлох	2
10	Олон улсын байгууллага, хамтын ажиллагаа, тусламж, хөнгөлөлт – эдийн засгийн дэмжлэг	Хөгжиж буй орнуудын уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх чиглэлээр хамтран ажиллах хувилбарууд, ОУ-ын байгууллагуудаас үзүүлж буй хөгжлийн хөтөлбөрүүд, хэрэгжилт, үр дүнг нэгтгэн авч үзэх	2
11	Алсын хараа, 2030-2050	Монгол улсын Засгийн газраас баталсан хөгжлийн төлөвлөгөө, тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, Монгол улсын 2030 болон 2050 хүртэл хөгжүүлэх алсын хараа бодлоогийн баримт бичиг	2
12	Сансар, огторгуй, далайн эрхзүйн асуудал- цэнхэр эдийн засаг-blue economy	Сансар, огторгуйн эрх зүй- Далайн нөөц, усны нөөцтэй холбоотой эрх зүй асуудлууд, олон улсын бүс, худалдааны зам, сансрын технологи хөгжил, ирээдүйн хөгжлийн сорил	2
13	Хөршийн (ОХУ, БНХАУ) ногоон хөгжил, ТХ-ийн бодлого, стратеги, үзэл баримтлалыг харьцуулах	Орос, Хятад гэсэн 2 багт хуваагдан судалгаа хийж, танилцуулна. Монгол улсын ТХ-ийн бодлого, стратегитай холбон авч үзэж, нөхцөл байдлын судалгаа хийнэ.	2
14	Байгаль орчинд ээлтэй буюу тогтвортой хөгжлийн жишээ судалгаа	Куритиба/Curitiba/ байгаль, хүнд ээлтэй хот Анкара /Ankara/ хог хаягдлын боловсруултаас хий, цахилгаан үйлдвэрлэх	2
15	Шинжлэх ухаан, технологийн хөгжлийн асуудал	Цахим шилжилт, виртауль орчны өөрчлөлттэй холбогдон ТХ-ийн чиглэлээр хийгдэж буй тэргүүлэх туршлага, үзэл санааг авч үзэхдээ гадаад орнуудын туршлагаас суралцах	2




Цахим хичээл:

- <https://online.num.edu.mn/>
- Хичээлээ сонгоно. ENVI402
- Хичээлд бүртгүүлнэ. Enroll in ENVI402
- Цахим сургалтын системд бүртгүүлнэ. Бүртгүүлэх заавар дагана.
- Нууц үгээ өөрчилсний дараа цахим сургалтын системд нэвтэрнэ.
- Хичээлээ сонгож ороод
 - Хичээлийн тодорхойлолт
 - Үндсэн сурах бичиг, нэмэлт судлах материал
 - Асуулт байвал хэлэлцүүлэг хэсэгт бичих
 - Явцаа харах боломжтой.

ЗААХ АРГА БАРИЛ – БҮРЭН ЦАХИМ ХИЧЭЭЛ

Сургах болон сурах үйл явц нь шавь төвт сургалтын арга барилд тулгуурлах ба лекц, харилцан яриа, семинар, бие даалт, тайлан бичилт, судалгаа гүйцэтгэх, мэдээ цуглуулах, түүнд анализ хийх, илтгэл тавих гэх мэт олон хэлбэрээр явагдана.


Бүртгүүлэх заавар



The screenshot shows the 'Sign In' page for the ENVI402 course. It includes a navigation menu with options like 'Хичээл', 'Хичээлийн тодорхойлолт', 'Үндсэн сурах бичиг', 'Нэмэлт судлах материал', 'Хэлэлцүүлэг', and 'Явц'. A notification banner at the top reads: 'Хүрээлэн буй орчны судалгаанд зайнаас тандан судлал ба газарзүйн мэдээллийн системийн хэрэглээ'. A message box states: '“Хүрээлэн буй орчны судалгаанд зайнаас тандан судлал ба газарзүйн мэдээллийн системийн хэрэглээ” хичээлийн хуудсанд тавтай морил!'. On the right, there are sections for 'Хичээлийн хэрэглүүр' (with links for 'Хадгалсан хуудсууд' and 'Шинэчлэлүүд') and 'Important Course Dates'. At the bottom, a note says: 'н оюутаны *****@stud.num.edu.mn цахим шуудангаа вичээд “reset my password” товч дээр дарна. Ингэснээр нууц үг солих холбоос очих болно.'

Цахим хичээл

<https://online.num.edu.mn/courses/course-v1:NUM+ENVI402+2022/course/>



Хүрээлэн буй орчны судалгаанд зайнаас тандан судлал ба газарзүйн мэдээллийн системийн хэрэглээ

NUM - ENVI402
Дууссан - May 31, 2022

Архивласан Хичээлийг Үзэх

Системд нэвтрэх



Sign In

Цахим шуудан

****@stud.num.edu.mn

'МУИС-ийн цахим хичээл' -д МУИС-ийн албан ёсны цахим шуудан ашиглана.

Нууц үг

[Forgot password?](#)

Remember me

Sign in

Хичээлийн тодорхойлолт үзэх



NUM: ENVI

Агаар мандлын динамик процесс, агаарын бохирдлын эрсдэлийг үнэлэх аргачлал

[Шинэ курсүүд үзэх](#)

[Хичээл](#)

[Хичээлийн тодорхойлолт](#)

[Үндсэн сурах бичиг](#)

[Нэмэлт судлах материал](#)

[Хэлэлцүүлэг](#)

[Явц](#)

[Зааварлагч](#)

Хичээлийн тодорхойлолтыг дараах холбоосоор орж үзнэ үү.

/static/Syllabus_-_Atmospheric_dynamic_process__Air_pollution_risk_assessment_-_Mon.docx

Лекц ба лабораторийн видео харагдах байдал

Илтгэл
[Bookmark this page](#)

Лаборатори 1: Газарзүйн солбицол, байр зүйн зураг

ENVI402 Лаб 1 Байрзүйн зураг

1:100 000 масштабын байр зүйн зургийн планшетын байрлал

© Professor O.Altanskh, School of Engineering and Applied Sciences, National University of Mongolia

Асуулт-хариултын хэсэг

Хичээлийг өөр эрхээр үзэх:

Хичээл | Хичээлийн тодорхойлолт | Үндсэн зурах бичиг | Нэмэлт судлах материал | Хэлэлцүүлэг | Явц

Хичээл 1: Агаар мандлын динамик
Хичээл > процессын тухай > Лекц > Асуулт, хариулт

« Previous | Next »

Асуулт, хариулт

[Bookmark this page](#)

Хэлэлцүүлэг Hide Discussion

Сэдэв: Week 1 / Topic-Level Student-Visible Label


Бүх бичлэгийг харуулах сүүлд өөрчлөгдсөн

There are no posts in this topic yet.

« Previous | Next »


Үндсэн сурах бичиг

Хичээл Хичээлийн тодорхойлолт Үндсэн сурах бичиг Нэмэлт судлах материал Лаборатори Хэлэлцүүлэг Явц Зааварлагч



Нэмэлт сургалтын материал

Үндсэн сурах бичиг Нэмэлт судлах материал Лаборатори Хэлэлцүүлэг Явц Зааварлагч



Хэлэлцүүлгийн хэсэг

Хичээл Хичээлийн тодорхойлолт Үндсэн сурах бичиг Нэмэлт судлах материал **Хэлэлцүүлэг** Явц Зааварлагч

All Topics Бичлэг нэмэх Search all posts Search

Сэдвүүдийг Шүүх
сэдвүүдийг шүүх

Бүх хэлэлцүүлэг

- ★ Миний дагаж байгаа бичлэгүүд
- Week 1
- Topic-Level Student-Visible Label (2)
- Topic-Level Student-Visible Label (9)
- Topic-Level Student-Visible Label (3)
- Topic-Level Student-

Discussion Home
Агаар мандлын динамик процесс, агаарын бохирдлын эрсдэлийг үнэлэх аргачлал

How to use 'МУИС-ийн цахим хичээл' discussions

Find discussions	Use the All Topics menu to find specific topics.	Search all posts	Filter and sort topics
Engage with posts	Vote for good posts and responses	Report abuse, topics, and responses	Follow or unfollow posts
Receive updates	Check this box to receive an email digest once a day notifying you about new, unread activity from posts you are following.		

Хичээлийн явц

NUM: ENVI
Агаар мандлын динамик процесс, агаарын бохирдлын эрсдэлийг үнэлэх аргачлал Шинэ курсууд үзэх

Тусламж altansukh

Хичээлийг өөр эрхээр үзэх: Суралцагч

Хичээл Хичээлийн тодорхойлолт Үндсэн сурах бичиг Нэмэлт судлах материал Хэлэлцүүлэг **Явц**

Course Progress for Student 'altansukh' (altansukh@num.edu.mn) [СТУДИД ДҮНГ ХАРАХ](#)

ИХ 01	ИХ 02	ИХ 03	ИХ 04	ИХ 05	ИХ 06	ИХ 07	ИХ 08	ИХ 09	ИХ 10	ИХ 11	ИХ 12	ИХ 13	ИХ 14	ИХ 15	ИХ 16	ИХ 17	Агуулга	C 02	C 03	C 04	C 05	C 06	C 07	C 08	C 09	C 10	C 11	C 12	C 13	C 14	C 15	С.Дүнлэг	УШ	Total		
0%	0%	0%	0%	0%	0%	0%	0%	0%	0%	0%	0%	0%	0%	0%	0%	0%	0%	0%	0%	0%	0%	0%	0%	0%	0%	0%	0%	0%	0%	0%	0%	0%	0%	0%	0%	0%





АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА